



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№162 /376/

2022.09.13

Цаг үе, үйл явдал

ХҮНДИЙН ӨРГӨЛТИЙН ТӨРӨЛД ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ АЛДАР СПОРТ ХОРООНЫ ТАМИРЧИД БАГИЙН ДҮНГЭЭР ДЭД БАЙРТ ШАЛГАРЛАА



Монголын бүх ард түмний спортын XV их наадмын Хүндийн өргөлтийн төрөлд Зэвсэгт хүчний Алдар спорт хорооны баг тамирчид багийн дүнгээр дэд байрт шалгарлаа.

Хүндийн өргөлтийн шигшээ тэмцээн есдүгээр сарын 10-11-ний өдрүүдэд болж өндөрлөлөө. Тэмцээнд 19 аймаг, 9 дүүргийн 200 гаруй тамирчин 14 жинд өрсөлдсөнөөс Зэвсэгт хүчний Алдар спорт хорооны ОУХМ Ч.Март, ОУХМ А.Отгонжаргал дасгалжуулагчтай баг тамирчид 10 алт 2 мөнгө, 2 хүрэл медаль хүртэж багийн дүнгээр дэд байрт шалгарлаа.

Тус спартакиадад 64 кг-ийн жинд Алдар спорт хорооны тамирчин ОУХМ Б.Хонгорзул 117 кг-ийг

түлхэж, Монгол Улсын рекордыг 4 кг-аар, 81 кг-ийн жинд ОУХМ 117 кг-ийг огцом өргөлтөөр өргөж 2 кг-р, 61 кг-ийн жинд ОУХМ Ө.Чагнаадорж 140 кг-ийг түлхэлттэй өргөлтөөр өргөж 5 кг-аар, 49 кг-ийн жинд ОУХМ Б.Эрдэнэзул

70 кг-ийг огцом өргөлтөөр өргөж 2 кг-аар Монгол Улсын рекордыг шинэчлэн тогтоосон нь онцлох үйл явдал боллоо. Мөн СДМ Ц.Минжинсор нь Спортын мастер, СМ Ка.Айнур нь ОУХМ цолны болзлыг тус тус хангалаа.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀ 26	🌧 10

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀ 30	🌧 22

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3.300	3.310
EUR 🇪🇺	3.385	3.410
CNY 🇨🇳	478	482
RUB 🇷🇺	51.20	52
JPY 🇯🇵	23.70	24.35
KRW 🇰🇷	2.40	2.41

ЗУРХАЙ



2022.09.13 /МЯГМАР ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 17

НАМРЫН ТЭРГҮҮН ШАР БИЧ САРЫН НАЙМАН ЦАГААН ШАРАГЧИН МОГОЙ ӨДӨР

Үс засуулбал:
Эд малын гарлагатай НАРАН УРГАХ, ШИНГЭХ: 06.26-19.10
Барилдлага:
Хучин төгсөх
ШҮТЭН БАРИЛДАГА:
Хүрэлцэхүй



Тухайлбал:

Эмэгтэйчүүдийн төрөлд:

- 49кг Б.Эрдэнэзул-алт
- 55кг Ка. Айнур-алт
- 59кг Э.Энхтамир-алт
- 64кг Б.Хонгорзул-алт
- 76кг Г. Отгонтуяа-мөнгө
- 76кг Ц. Минжинсор- хүрэл
- +87кг М. Анхцэцэг- алт



Эрэгтэйчүүдийн төрөлд:

- 61кг Ө.Чагнаадорж- алт
- 67кг Г. Ууганбаатар-мөнгө
- 73кг Б. Оргилсайхан-алт
- 81кг Ө.Даваагомбо-алт
- 96кг Д. Доржнамжим-мөнгө
- 109кг А. Амартөгс-алт
- 109кг Н. Галсандорж-хүрэл
- +109кг Р. Мөнх-Оргил- алтан медаль тус тус хүртлээ.

Тухайн өдөр үхэр жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн.

Эл өдөр буян номын үйлийг эхлэх, дээдсээс халамж хүсэх, лам хувраг болох, багш шавьд барилдах, номын абшиг авах, шинэ гэр ба байр авах, сан тавиулах, угаал үйлдэх, газар лусын зан үйл хийх, өр барагдуулах, буг дарах, газрын ам бооход сайн. Ургаа мод таслах, газрын ам нээх, сэтгэлд сэвтэй газар очих, байшингийн суурь тавихад муу.

Хол газар яваар одогсод баруун хойд зүгт мөрөө гаргавал зохистой.

ӨВӨЛ СУРГУУЛИЙН БЭЛТГЭЛ АЖЛЫГ ШАЛГАНА



Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч, бригадын генерал Ж.Болдбаатараар ахлуулсан ажлын хэсэг энэ сарын 14-16-ны өдрүүдэд БХЯ-ны харьяа байгууллагуудын өвөл сургуулийн бэлтгэл ажлыг шалгана.

Ажлын хэсэг нь байгууллагуудын төрийн албан хаагчийн ёс зүйн зөвлөл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, сахилга хариуцлагыг бэхжүүлэх зөвлөлийн үйл ажиллагаа, өвөл сургуулийн бэлтгэл ажил, ажлын байрны нөхцөл зэрэгтэй танилцаж, үнэлэлт дүгнэлт өгөх юм.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 614,346,277

Эдгэрсэн

Нийт: 593,365,328

Нас барсан

Нийт: 6,518,149

ЦАХИМ ШУУДАНД

**БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙДЫН НЭРЭМЖИТ 2022 ОНЫ
"ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ШИЛДЭГ БҮТЭЭЛ"
ШАЛГАРУУЛАХ УРАЛДААНЫГ ЗАРЛАЖ БАЙНА**

Улс орныг батлан хамгаалах үйл оюуны чадавх, мэдлэгийг арвижуулах, шилдэг ажиллагаанд шинжлэх ухаан, технологи, бүтээлүүдийг сурталчлах зорилгоор Монгол инновацын үр дүнг нэвтрүүлэх, түүний Улсын Батлан хамгаалахын сайдын нэрэмжит хөгжлийг дэмжих, эрдэм шинжилгээний "Шинжлэх ухаан, технологийн шилдэг бүтээл" ажилтнуудын идэвх, санаачилгыг өрнүүлэх, шалгаруулах уралдааныг зарлаж байна.

Шинжлэх ухаан, технологийн шилдэг бүтээлийг дараах 9 төрлөөр шалгаруулна:

- Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал
- Цэргийн ухаан
- Цэргийн түүх судлал
- Цэргийн зэвсэглэл
- Цэргийн техник
- Цэргийн инновацын дэвшил
- Цэргийн технологийн дэвшил
- 35 хүртэлх насны залуу судлаачийн бүтээл
- Шинэ бүтээл, оновчтой санал

Эрдэмтэн, судлаачдын эрдэм шинжилгээ, судалгаа, туршилт, зохион бүтээх ажлын үр дүнд бий болсон, улс орноо батлан хамгаалах эрх ашиг, цэргийн шинэчлэлд дорвитой хувь нэмэр оруулсан аюулгүй байдал, батлан хамгаалахын болон цэргийн шинжлэх ухааны онол, урлаг, арга зүйн ном, нэг сэдэвт бүтээл (монограф) болон инновац, технологийн дэвшлийг тусгасан, зэвсэглэл, техникийн зохион бүтээгдсэн ажил, эрдэм шинжилгээ, судалгааны ажилд зориулан гаргасан бүтээлийг шалгаруулалтад оруулна.

Шалгаруулалтад ирүүлэх бүтээлд "Батлан хамгаалахын сайдын нэрэмжит шинжлэх ухаан, технологийн шилдэг бүтээл шалгаруулах журам"-ын 2 дугаар зүйлд заасан шаардлага тавигдана.

Шалгаруулалтад нэр дэвшүүлж буй бүтээл нь тавигдах шаардлага, журамд заасан зохих бүрдүүлэлтийг хангасан байх ба түүнийг бүрдүүлсэн материал, баримт бичгийн хамт зохиогч эсвэл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс Батлан хамгаалах яамны Шинжлэх

ухаан, технологийн зөвлөлийн эрдэмтэн нарийн бичгийн дарга 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 9.00 цагаас мөн сарын 25-ны өдрийн 18.00 цагийн дотор хүлээн авч, яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөл шалгаруулна.

Шалгарсан бүтээлийн төрөл тус бүрд "Шинжлэх ухаан, технологийн шилдэг бүтээл"-ийн өргөмжлөл, мөнгөн урамшуулал олгоно. Шинжлэх ухаан, технологийн шилдэг бүтээлийн шагналыг "Шинжлэх ухааны ажилтны өдөр"-өөр гардуулна.

Холбоо барих утас: 51-263202

Цахим шуудангийн хаяг: sodnomtsog.d@mod.gov.mn

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНЫ ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ЗӨВЛӨЛ



**ТҮҮХТ ОЙН ӨДӨР БИД БҮХЭН
АМ БҮЛ НЭМЛЭЭ**

Дээд удирдлагын гаргасан шийдвэрийн дагуу Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэл, 014 дүгээр ангиудын хугацаат цэргийн алба хаагчдын дунд "Гэрээт цэрэг-Гэрэлтэй алба" сурталчилгааны арга хэмжээг зохион байгууллаа

Зэвсэгт хүчинд Хуягт танкын цэрэг үүсэж хөгжсөний түүхт 79 жилийн ойн өдөр хугацаат цэргийн албанаас, гэрээт цэргийн албанд элсэн орж байгаа нэгдүгээр ээлжийн 29 алба хаагчийг ангийн байрлалд хүлээн авч хүндэтгэл үзүүлээ.

Түүний дараагаар цэргийн алба хаагчдын ар гэрийн төлөөллийг хүлээн авч уулзан гурвалсан гэрээг байгуулж 10 дугаар сарын 3-ны өдрөөс албан ажилдаа орохыг үүрэг болгов.

Ангийн захирагч, хурандаа Ж.Сүх-Очир хугацаат цэргийн албанаас өөрсдийн хүсэл мөрөөдлийнхөө дагуу Зэвсэгт хүчний 350 дугаар ангийг сонгон гэрээт цэргийн албанд элсэж байгаа эрхэм дайчдадаа өргөсөн тангарагтаа үнэнч байхыг захиад эх орноо батлан хамгаалах ариун их үйлсэд нь амжилт бүхний дээдийг хүсжээ.



**"УРАН ЖОЛООДЛОГО" ТЭМЦЭЭНИЙГ
ЗОХИОН БАЙГУУЛЛАА**

Зэвсэгт хүчний Барилга Инженерийн цэргийн удирдах газраас зохион байгуулж буй "Замын хөдөлгөөний аюулгүй байдал, техникийн бэлэн байдал, аюулгүй тээвэр" аянд 338 дугаар анги нэгдлээ.

Аяны хүрээнд 338 дугаар ангийн Зэвсэгт техникийн алба, Сүхбаатар аймгийн Цагдаагийн газартай хамтран тэмцээний үеийн техникийн аюулгүй байдлыг хангуулж ангийн бие бүрэлдэхүүний дунд "Уран жолоодлого" тэмцээнийг амжилттай зохион байгуулж явууллаа.

Дэслэгч Б.Пүрэвлхам

**СУМДЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
НАР ХОВД АЙМАГТ
"ЦЭРГИЙН БЭЛТГЭЛ" СУРГАЛТАД
ХАМРАГДАЖ БАЙНА**



"Дайчилгааны тухай" Тамгын газрын дарга Монгол Улсын хууль болон Д.Энхболд болон баруун Батлан хамгаалахын бүсийн аймгуудын Засаг даргатай байгуулсан Цэргийн штабын дарга нар хамтран ажиллах гэрээ, Цэргийн штабын сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу Баруун бүсийн аймгуудын сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нартай зохион байгуулах "Цэргийн бэлтгэл" сургалтыг Ховд аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабаас 2022 оны 9 дүгээр сарын 11-14-ний өдрүүдэд зохион байгуулж байна.

Өнөөдөр зохион байгуулагдсан "Цэргийн бэлтгэл" сургалтын нээлтийн арга хэмжээнд Ховд аймгийн Засаг дарга бөгөөд Баруун бүсийн зөвлөлийн дарга хатагтай Э.Болормаа, Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга хурандаа Ч.Гандирваа, Ховд аймгийн Засаг даргын

Тамгын газрын дарга нар болон Цэргийн штабын офицерууд хамрагдаж байна. Энэхүү сургалт нь Засаг даргын Тамгын газрын дарга нарыг дэлхийн болон бүс нутгийн аюулгүй байдлын орчны өөрчлөлт, Монгол Улсын батлан хамгаалах бодлого, Зэвсэгт хүчний шинэчлэлт, өөрчлөлтийн талаар шинэ мэдээ, мэдээллээр хангах, орон нутагт Батлан хамгаалах бодлого, зорилтыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зэрэг чухал ач холбогдолтой арга хэмжээ болж байна.

Тус сургалтад баруун бүсийн 5 аймгийн 90 гаруй сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нар болон Цэргийн штабын офицерууд хамрагдаж байна. Энэхүү сургалт нь Засаг даргын Тамгын газрын дарга нарыг дэлхийн болон бүс нутгийн аюулгүй байдлын орчны өөрчлөлт, Монгол Улсын батлан хамгаалах бодлого, Зэвсэгт хүчний шинэчлэлт, өөрчлөлтийн талаар шинэ мэдээ, мэдээллээр хангах, орон нутагт Батлан хамгаалах бодлого, зорилтыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зэрэг чухал ач холбогдолтой арга хэмжээ болж байна.

ФОТО АГШИН



АХМАДУУДДАА ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЛЭЭ

Зэвсэгт хүчний 032 дугаар анги удирдлага, хамт олноос Төв аймгийн Баянчандмань суманд оршин суугаа ахмад настан А.Нямсүрэн, М.Сувдаа нарт хүндэтгэл үзүүлж, Ардын хувьсгалын 100 жилийн ойн хүндэт медаль, дурсгалын зүйлийг гардуулан өгчээ.